

Иргэн болж төрсөндөө харамсахгүй юмсан


НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс дөрвөн жил тутамд дэлхийн 192 гишүүн орнуудаас нэгийг нь онцолж, тухайн улсад хүний эрх, эрх чөлөөг хэрхэн хангадаг, олон улсын болон иргэдийнхээ өмнө амалсан үүргээ биелүүлж чадаж байгаа эсэхэд нь үнэлэлт дүгнэлт хийдэг байна. Энэ удаагийн ээлжит хэлэлцүүлгээр Монгол улсыг сонгож, хүний эрхийн зөрчлийн асуудлыг хэлэлцэх аж. Энэхүү хэлэлцүүлэг 2010 оны 11 дүгээр сарын 23 ны өдөр Женев хотноо болох бөгөөд үр дүнгээс хамаарч Монгол улсын Засгийн газарт хандсан зөвлөмжүүд гаргах юм байна. Харин Хэлэлцүүлэгт зориулсан илтгэлийг Монгол улсад үйл ажиллагаагаа явуулж буй гадаадын болон дотоодын төрийн бус байгууллагууд хамтран хүний эрхийн зөрчлийн талаар бичиж, ирэх сарын сүүлээр явуулах аж. Энэхүү тайланд Байгаль орчин, уул уурхай, хүнсний эрх, цөөнхийн эрх, шилжин суурьшигчдийн эрх, сонгох сонгогдох эрх зэрэг асуудлуудыг гол болгон бичих гэнэ.

Үндэстний цөөнх

Яс үндэс, хэл соёлоороо ондоо гэж хэлэгддэг казак, буриад, цаатан зэрэг үндэстний цөөнхийн эрх зөрчигдөж байгааг талаар хэлэлцэх гэнэ. Өнгөрсөн зууны их хэлмэгдүүлэлтийн үеэр яс үндэс, хэл соёлоосоо болон гадуурхагдаж, амь насаа алдаж байсан гашуун үнэнг түүх өгүүлдэг. Одоо ч гэсэн тодорхой хэмжээгээр тэдний хэл соёл, үндэстний онцлогийг илүүд үзэж, хошин шогийн зарим тоглолтуудад бусдыг баясгах зугаа болгон харуулах, албан байгууллагууд ажилд авахдаа хэлтгий хэлтэйгээс гадна авир муутай хүмүүс байдаг хэмээн ад үзэх, ялгаруулах асуудал байсаар байгаа. Монгол улсын үндсэн хуулинд яс үндэс, хэл соёл, шашин шүтлэгээр ялгаварлан гадуурхахгүй гэж заасан байдаг ч энэ нь амьдрал дээр хэрэгждэггүй. Тэдэнд зориулсан нөвтрүүлэг, мэдээ мэдээлэл, урлаг соёлын арга хэмжээ бараг л байхгүй. Учир нь хонжоо хайсан зах зээлийн өнөөгийн нийгэмд ашиг авчиргахгүй гэж үздэгээс болдог гэнэ. Сүүлдээ үндэстний цөөнх болсон тэдний залуу үе яс үндэс хэл соёлоосоо ичих, уг гаралаа нуух зэргээр Дэлхий нийтэд гайхуулж байсан түүх соёлын өв мөхөх аюул нүүрлээд байна.

Бэлгийн цөөнх

Хүний бэлгийн чиг хандагаас шалтгаалан гадуурхах явдлыг Дэлхийн улс орнууд эсэргүүцдэг. Харин манай орны хувьд эвэртэй туулай үзсэн мэт тэдний тухай сэм ярилцаж, шоолох, үзэн ядах зэргээр илт гадуурхангүй ханддаг. Гадуурхаж гоочлон тэднийг илүү



үзсэнээс нууц далд байдалд орж, эрхээ эдэлж чадахгүй байгаагаас гадна залуу үеийн сэтгэлгээнд сонирхох, үзээд алдах хүслийг төрүүлдэг. Яагаад гэвэл монголчуудын сэтгэхүйд хожмын үр дагаварыг бодохгүйгээр болохгүй гэсэн бүхнийг биеэрээ турших дуртай байдаг. Энэ нь мэдээлэл хаалттай, дээр нь тодорхой хүрээллийг л хамардаг. Үнэндээ бэлгийн чиг хандлага гэдэг нь тэр хүний хэн байхаас шалтгаалдаггүй төрөлхийн хэв шинж байдаг.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд

Төрөлхийн болон гэнэтийн осол, аваараас болон хөгжлийн бэрхшээлтэй хэмээн цоллуулсан иргэдийн эрх манайд хамгийн ихээр зөрчигдөж байгаа. "Цоллуулсан" гэдгийн учир нь оны өмнө хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах талаар НҮБ-ийн Хүний эрхийн зөвлөлөөс энэ зуунд гаргасан хамгийн сүүлийн конвенцийг баталж, Монгол улсад мөрдөх журам явуулжээ. Гэтэл хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах, өдөр тутмын амьдралд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа өдийг хүртэл явуулаагүй гэхэд болохоор байгаа тухай тэд хэлж байсан. Улсаас сард олгодог мөнгөн тэтгэмж нь 36 хан мянган төгрөг. Энэ нь улсаас олгож байгаа ганц тэтгэмж нь. Бусад нийгмийн асуудлууд орхигддог. Тэд хэн нэгний мэдэлд байж, хэн наашаа харсанд л өөрсдийгөө даатгах болдог. Хэдийгээр аль нэг эрхтэн тогтолцоо нь дутуу эсвэл гэмтэж бэртэн эд эрхтэн нь бүтэн биш ч бодож сэтгэдэг, хийж бүтээх гэсэн хүсэл эрмэлзэл дүүрэн байдаг. Тэдэнд зориулсан ном сурах бичиг хангалтгүй, мэдээлэл хомсхон, тусгай сургуульд сургах нэрээр нийгмээс тусгаарлаж орхидог. Мөн тэдний эрхийг зөрчиж байгаа өөр нэг асуудал

бол гэрээсээ өөр газарт явах, зорчих эрх үгүй. Ялангуяа тэргэнцэртэй хүн гэрээсээ гарахад цахилгаан шат, албан байгууллага, дэлгүүрийн шатаар яаж зорчих вэ гэсэн хүндрэлээсээ болоод бие даан явж чаддаггүй. Зарим албан байгууллага тусгай зам гаргасан байдаг ч тэр нь тэрэгтэй хүн байтугай жирийн хүн ч явах аргагүй байдаг. Үнэндээ тэд бидэнтэй л адил монгол улсын иргэн, жирийн л нэг хүмүүс. Бусадтай ижил тэгш эрх эдлэх ёстой.

Зах зээлд шилжсэн тэр цагаас л Монгол улсын хэмжээнд нийгмийн бүхий л салбаруудад ноцтойгоор болон санамсаргүй байдлаар хүний эрх зөрчигдөж эхэлсэн. Тийм болохоор Засгийн газрын болон Монгол улсын үнэн бодит байдлыг илтгэлдээ тусгах үүргийг төрийн бус байгууллагууд бүрэн хариуцна гэж хэвлэлийн хурлаар мэдэгдлээ. Үнэндээ Дэлхийн улс орнуудад Монгол орны бодит байдлыг харуулсан илтгэлийг бичиж, Засгийн газрын бодлогын алдаа, иргэдийн амьд явах эрх, эрүүл аюулгүй орчинд амьдрах, элдэв дарамт шахалтгүй, хэн нэгэнээс айж үг хэлэх эрх чөлөө нь улам бүр хумигдаж буй нийгмийн ялзралыг гаргаж чадвал жинхэнэ хүний эрхийн төлөө чиглэсэн ажил болно. Иймд Монгол улсын иргэн болж төрсөн хэн бүхэн хүний амьдралын хамгийн наад захын хэрэглээ, аюулгүй эрүүл орчинд амьдрах эрх нь зөрчигдөж байгааг илтгэлдээ тусгах хэрэгтэй. Ингэж гэмээ нь Монгол улсын засгийн газар олон улсын өмнө амлалт өгч, иргэдийнхээ эрхийг эдлүүлэх болов уу. Монгол улсын иргэн болж төрсөн л бол аливаа нэг "онцлогоосоо" болж харамсахааргүй, харин ч бусдын л адилаар БИ МОНГОЛ ХҮН бахархалтайгаар хэлж байх ёстой юм. Хүн бүхэн санатугай.

П.НАРАНДЭЛГЭР